МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.10.21 № 92

БОЛОВСРОЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
боловсролын асуудлаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хангахтай холбоотой хууль тогтоомж, тэгш хамран сургах чиглэл, журмын хэрэгжилт, хүрсэн үр дүн болон хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээг тодруулах шаардлагатай байна. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

Асуудал тус бүрээр хэрэгжилт, хүрсэн үр дүн, хэрэгжилт хангалтгүй байгаа бол түүний шалтгаан, арилгах арга хэмжээ, хариуцах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах санхүүжилт, эх үүсвэрийг холбогдох судалгаа, тоон мэдээлэл, холбогдох төсөв, санхүүжилтийн мэдээллийг 2026 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан дүнгээр харьцуулан, хамрагдалтын мэдээллийг боломжтой хүрээнд насны бүлэг, боловсролын түвшин, аймаг, нийслэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар ангилан ирүүлнэ үү.

1.3-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол, хөгжлийн дэмжлэг, сургуульд бэлтгэх үйлчилгээнд хамруулах зохицуулалтын хэрэгжилт, хамрагдалт, хэрэгцээ, санхүүжилт ямар түвшинд байгаа талаарх болон шаардлагатай үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдийг хамруулах, цэцэрлэгээс сургуульд шилжих үеийн дэмжлэгийг тасралтгүй хүргэхэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар;

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын санхүүжилтийн аргачлал нь хүүхдэд шаардлагатай дэмжлэгийн бодит хэрэгцээ, түвшнийг хэрхэн харгалзан үзэж байгаа, хэрэгжилтэд ямар хүндрэл тулгарч байгаа талаар; санхүүжилтийг зөвхөн хөгжлийн бэрхшээлийн төрөл, оношид бус дэмжлэгийн хэрэгцээнд үндэслэн тооцдог тогтолцоонд шилжүүлэх талаар яамны баримталж буй бодлого, судалгаа, тооцоо, төлөвлөгөө болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан арга хэмжээний талаар;

3.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан хувьсах зардлын нэмэгдүүлсэн санхүүжилтийн хэмжээ, хуваарилалт, зарцуулалт, хүүхдийн дэмжих үйлчилгээнд үзүүлсэн үр дүнгийн талаар; зориулалтын зарцуулалтыг хянах, тайлагнах зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, хяналтаар илэрсэн зөрчил, тэдгээрийг арилгасан байдал болон хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох арга хэмжээний талаар;

2026000212

4.Туслах багшийн хэрэгцээг сургууль, суралцагчийн бодит хэрэгцээнд үндэслэн тогтоох, шаардлагатай дэмжлэгийг хүргэх зохицуулалтын хэрэгжилт, шаардлагатай болон ажиллаж буй туслах багшийн тоо, орон нутгийн хүртээмжийн талаар; хэрэгцээг хангахад тулгамдаж буй хүндрэл, дутагдалтай орон тоог нөхөх, цалин, сургалтын зардлыг тогтвортой санхүүжүүлэх арга хэмжээ болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан санхүүжилтийн талаар;

5.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хүүхдийн ахицад үндэслэн шинэчлэх зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, хамрагдсан суралцагчийн тоо, хүрсэн үр дүнгийн талаар; төлөвлөгөөг бодитоор хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, арга зүй, санхүүжилтийн хэрэгцээ, хэрэгжилтийн хүндрэл болон тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар;

6.Багш, туслах багш, дэмжих үйлчилгээний мэргэжилтнүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр чадавхжуулах ажлыг хэрхэн зохион байгуулсан, сургалтын агуулга, давтамж, хамрагдалт, санхүүжилт, үр дүнгийн талаар; сургалтыг тогтмол зохион байгуулах, орон нутгийн хүний нөөцийг хамруулахад тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх төлөвлөгөө болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан зардлын талаар;

7.Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн туслах бүтээгдэхүүн, дэмжих технологи, тохирох хэрэглэгдэхүүн, мэргэжлийн дэмжих үйлчилгээг хүргэх зохицуулалтын хэрэгжилт, хэрэгцээ, хангамж, санхүүжилтийн талаар; сурах бичиг, цахим сургалтын платформ, сургалтын материал, тоног төхөөрөмжийг хараа, сонсгол болон бусад ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд хүртээмжтэй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүн, хангагдаагүй хэрэгцээг шийдвэрлэх арга хэмжээ болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан зардлын талаар;

8.Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын болон хөгжлийн дэмжих үйлчилгээ хүргэх ажлын хэрэгжилт, хүний нөөц, хүртээмж, санхүүжилтийн талаар; төвлөрсөн дэмжих үйлчилгээг орон нутагт хүргэх, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээтэй уялдуулахад тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх зохицуулалт, санхүүжилтийн механизм, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

9.Төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг, сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалт, санхүүжилт, дэмжих үйлчилгээний мэдээллийг нэгтгэн бүртгэх тогтолцооны хэрэгжилтийн талаар; боловсролд хамрагдаагүй болон сургуулиас завсардсан хүүхдийг илрүүлэх, шалтгаан, дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох, боловсролд хамруулах ажлын үр дүн, хамрагдаагүй хэвээр байгаа хүүхдийн тоо болон цаашид авах арга хэмжээний талаар;

10.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд элсүүлэх, дунд болон ахлах ангид үргэлжлүүлэн суралцах эрхийг хангах зохицуулалтын хэрэгжилтийн талаар; элсүүлэхээс татгалзсан, суралцах боломжийг хязгаарласан талаарх гомдол, тэдгээрийн шийдвэрлэлт, хариуцлага тооцсон байдал болон ийм зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн суралцах эрхийг баталгаажуулах арга хэмжээний талаар;

11.Шинээр барих болон засварлах цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжид хүртээмжийн шаардлагыг хангах, холбогдох зардлыг төсөвт тусгах зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа талаар; төсөл төлөвлөх, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн

2026009212

авах үед хүртээмжийг үнэлсэн байдал, хяналтаар илэрсэн зөрчил, тэдгээрийг арилгасан үр дүнгийн талаарх тайлбар. Мөн одоо ашиглаж буй барилга, сургалтын орчны хүртээмжийн үнэлгээ, шаардлагатай тохируулга, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, санхүүжилтийн талаарх мэдээлэл;

12.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн болон суралцахуйн ахиц, дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг ямар шалгуур үзүүлэлтээр үнэлж байгаа, үнэлгээний үр дүнг бодлого, төсвийн төлөвлөлтөд хэрхэн ашиглаж байгаа талаар болон тэгш хамруулах боловсролд зориулсан төсөв, зарцуулалт, үр дүнг ялган тайлагнах, хүртээмжтэй хэлбэрээр нийтлэх болон төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эцэг эх, асран хамгаалагч, тэдний төлөөллийн байгууллагын оролцоог хангах ажлын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.САРАНЧУЛУУН

2026007213